

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС ЦАХИМААР САНАЛ ХУРААХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Цахимаар санал хураах ажиллагааг дараах дэс дарааллаар зохион байгуулна. Үүнд:

1. Цахимаар санал хураах тухай ТУЗ-ийн шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсний дараа буюу 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2021 оны 04 дүгээр 02-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2021 оны 03 дугаар сарын 25 болон 4 дүгээр сарын 07-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр болон олон нийтийн сүлжээгээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх ажлыг хурал зохион байгуулах комисст хариуцан хэрэгжүүлнэ.
2. Цахимаар саналаа өгөх хувьцаа эзэмшигч нь “Ариг гал” ХК-ийн цахим хуудсаар хурлын материалтай танилцаж, mb\_ocean@yahoo.com цахим хаягаар “Саналын хуудас”-ыг бөглөн ирүүлэх бөгөөд өөрийн Иргэний үнэмлэхийн хуулбарыг мөн цахимаар хавсаргаж ирүүлнэ. Энэ нь тухайн иргэнийг компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган шалгах зорилготой .
3. Цахимаар ирүүлсэн саналын хуудсыг тооллогын комиссын 3 гишүүн бүгд байлцан тоолж хүлээн авах бөгөөд цахимаар болон бусад хэлбэрээр ирүүлсэн саналын хуудсыг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12 цагаар тасалбар болгон ҮЦТХТ-өөс хүлээн авсан тархалтын мэдээтэй тулган хувьцаа эзэмшигчдийн биеийн байцаалтыг санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган шалгаж, хувьцаа эзэмшигч мөн болохыг баталгаажуулсын дараа нэрийг нь бүртгэлийн жагсаалтад бүртгэж битүүмжилсэн хайрцагт санаоын хуудсыг хийнэ. Санал хураах хуудсыг хүлээн авах бүртгэх шалгах ажиллагаанд, хурал зохион байгуулах комиссын гишүүд хяналт тавьж хэрэгжүүлнэ.
4. Хурал хуралдахаар тогтоосон өдөр буюу 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хурлын саналын хуудас тоолохоор Тоологын комисс ажилд орсон үед Тооллогын комиссын гишүүд биеэр хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас болон битүүмжилсэн хайрцагийг нээх, санал тоолох, тооллогын дүнг гаргах, Тооллогын комиссын тогтоолыг албажуулан гаргах ажиллагааг Хурлын дарга болон гишүүдийн хяналтын дор хэрэгжүүлнэ.

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ДЭГ

1. Хурлын ирцийг бүртгэх, санал хураах хуудсаар оролцож байгаа саналын дүнг нэгтгэж ирцийг мэдээлэх  
(тооллогын комисс 25 мин)
2. Хурлын үйл ажиллагааг нээх  
(Хурлын дарга 5 мин)
3. “Ариг гал” ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх тайланг хэлэлцүүлэх  
(Тэргүүн дэд захирал А.Төмөр очир 20 мин)
4. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлэх  
(ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Б. Аюуш 20 мин)
5. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдэд нэр дэвшигчдийн талаар танилцуулга хийх  
(ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн Б.Болд 30 мин)
6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах  
(Тэргүүн дэд захирал А.Төмөр очир 10 мин)
7. Компанийн удирдлагын 2021 оны зардлын төсөвийг хэлэлцүүлэх  
(АА-ны СТА-ны ЕМ Д.Мөнхбаатар 10 мин)
8. ТУЗ-ийн охин компанид биет хөрөнгөөр, оруулалтыг нэмэгдүүлэх тухай 2020 оны 08/20 болон хөрөнгийн эх үүсвэр гаргах тухай 10/20 тоот шийдвэрүүдээр мэдээлэл хийж тогтоолудыг дэмжүүлэх тухай  
(ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав 15 мин)
9. Санал шүүмжлэл явуулах  
(Хүн тус бүрт 5 мин)
10. Санал хураалт явуулах, санал хураалтын тооллогын дүнг танилцуулах  
(Тооллогын комиссын дарга Ч.Энхцэцэг 15 мин)
11. Хурлаас гарах тогтоолын төслийг хэлэлцүүлж батлуулах  
(Хурлын дарга Д.Гиваапил 20 мин)

Хурлыг 2.00 цагт багтаан явуулна

Хурал зохион байгуулах комисс

Ариг гал ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулах  
Гүйцэтгэх захирал Х.Хания-гийн тайлан

Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Уламжлал ёсоор “Ариг гал” ХК -ийн хувьцаа эзэмшигчиддээ, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс, өнгөрсөн хурлаас хойш хийсэн ажил, тавьсан зорилгоо хэрхэн хэрэгжүүлснээ өнөөдөр тайлагнаж байна.

Тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас өмнөх хурлаар дэвшүүлсэн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан явууллаа. Үүнд:

**Нэг. Борлуулалтын орлогын талаар**

Манай компани түрээсийн орлого, ноогдол ашиг гэсэн хоёр үндсэн эх үүсвэрээс орлогоо бүрдүүлдэг. Өнгөрсөн онд хуралдсан бүх гишүүдийн хурлаас 2020 онд 1,715.0 сая төгрөгийн орлоготой байхаар төлөвлөсөнөөс 1,927.9 сая төгрөг буюу төлөвлөсөнөөс 12.0%-иар өссөн ч өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 3%-иар буурсан байна. Түрээсийн орлого 236,1 сая.төгрөгт болж төлөвлөсөнөөс 41 %иар, өмнөх онтой харьцуулахад 30 %-иар буурсан нь түрээслэг чнар олон сар орлогогүйгээс гэрээцээ цуцлсантай холбоотой. Харин ногдол ашгийн орлого төлөвлөснөөс 28%-иар өссөнөөс орлого ерөнхийдөө бага зэрэг өсөлттэй харагдаж байна. биелэлттэй байна. 2020 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Ариг гал ХК-ийн 2020 оны орлого, үр дүнгийн харьцуулалт /мян.төг/

дд	Үзүүлэлт	2019 оны		2020 оны		2021 оны төлөвлөгөө
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	Борлуулалтын орлого	2,415,000.00	1,994,327.9	1,715,000.0	1,927,911.1	1,090,000.0
	Үүнээс: түрээсийн	400,000.0	335,843.3	400,000.0	236,144.1	400,000.0
	Бусдаас авсан ногдол ашиг	2,000,000.0	1,637,243.0	1,300,000.0	1,663,755.0	675,000.0
	Бусад орлого	15,000.0	21,241.6	15,000.0	28,011.7	15,000.0
2	Нийт зардал	1,775,582.0	1,719,231.5	1,411,717.0	1,514,331.5	980,810.0
3	Нийт ашиг	639,418.0	275,096.4	303,283.0	413,579.6	109,190.0
	Ашгаас санхүүжүүлэх зардал	15,000.0	155,481.1	15,000.0	75,348.0	15,000.0
	ААНОАТ	23,380.9	1,502.2	23,380.9		
	Цэвэр ашиг	601,037.1	118,113.1	264,902.1	338,231.6	94,190.0

**Хоёр. Санхүүгийн байдлын талаар**

2020 оны тайлан балансаар үйл ажиллагааны зардал 87,6 сая төгрөгөөр буюу 12%-иар өссөн. Цалин, НДШ, ашиглалтын зардал 63,1 сая төгрөгөөр буурсан ч бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 50.2 сая төгрөгөөр өссөн байгаа.

Санхүүгийн тайлан балансаас харахад өнгөрсөн 2020 онд төлөвлөсөн зардлаас 34%иар бууруулсан харагдаж байна. Ногдол ашгийн орлого 1,6 тэрбум төгрөг орж ирснийг охин компани болох Кашмер холдинг ХХК-д түүхий эдийн санхүүжилтанд олгосон. Балансын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хураангуй балансаас харна уу.

**АРИГ ГАЛ ХК-ИЙН 2020 оны жилийн эцсийн хураангуй БАЛАНС (мян. төг-өөр)**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ҮЛДЭГДЭЛ		ӨСӨЛТ, БУУРАЛТ	
	Эхний	Эцсийн	тоогоор	хувиар
А. Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө	36,929,919.3	36,948,844.2	18,924.90	0.1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	121,221.5	141,512.4	20,290.90	16.7%
Авлага	36,777,665.0	36,776,299.0	(1,366.00)	

Үндсэн туслах материал	31,032.8	31,032.8	-	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			-	
2. Биет хөрөнгийн дүн	2,934,629.8	2,774,413.0	(160,216.80)	-5.5%
Барилга байгууламж	4,424,365.4	4,391,899.6	(32,465.80)	-0.7%
Машин, тоног төхөөрөмж	7,142.0	7,142.0	-	
Тавилга эд хогшил	55,747.1	60,052.1	4,305.00	7.7%
Хуримтлагдсан элэгдэл	(1,641,174.7)	(1,773,230.7)	(132,056.00)	8.0%
Бусад	88,550.0	88,550.0	-	
3. Биет бус хөрөнгийн дүн	487,040.7	528,962.2	41,921.50	8.6%
4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	20,010,109.4	18,230,411.2	(1,779,698.20)	-8.9%
Нийт хөрөнгийн дүн	60,361,699.2	58,482,630.6	(1,879,068.6)	-3.1%
<b>Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			-	
1. Өр төлбөрийн дүн			-	
Богино хугацаат өр төлбөр	49,863,992.9	49,484,363.8	(379,629.10)	-0.8%
Урт хугацаат өр төлбөр	591,176.6	566,219.4	(24,957.20)	-4.2%
Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр			-	
2. Хувьцааны дүн	347,932.0	347,932.0	-	
Энгийн хувьцааны тоо, ширхэг	3,479,320.0	3,479,320.0	-	
Нэрлэсэн үнэ	0.1	0.1	-	
Давуу эрхийн хувьцааны тоо, ширхэг	-	-	-	
Нэрлэсэн үнэ			-	
Халаасны хувьцааны дүн	(9,142.8)	(9,142.8)	-	
3. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,598,730.6	6,598,730.6	-	
4. Хуримтлагдсан ашиг	2,743,255.6	1,159,097.2	(1,584,158.40)	-57.7%
Тайлант үеийн ашиг	225,754.3	335,430.4	109,676.10	48.6%
5. Эзэмшигчийн өмчийн дүн	9,906,529.7	8,432,047.4	(1,474,482.30)	-14.9%
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>60,361,699.2</b>	<b>58,482,630.6</b>	<b>(1,879,068.6)</b>	<b>-3.1%</b>

Орлогын тайлан

Мян.төг

Санхүүгийн үзүүлэлт	2019 он	2020 он	Өсөлт бууралт	
			дүнгээр	хувиар
Борлуулалт	341,673.2	236,144.2	(105,529.00)	-31%
Цэвэр борлуулалт	341,673.2	236,144.2	(105,529.00)	-31%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15.3			
Ашиг	<b>341,657.9</b>	<b>236,144.2</b>	(105,513.70)	-31%
Үйл ажиллагааны зардал	735,817.2	823,477.8	87,660.60	12%
Үйл ажиллагааны бус орлого	1,652,264.7	1,691,767.0	39,502.30	2%
Үйл ажиллагааны бус зардал	1,030,849.0	766,201.8	(264,647.20)	-26%
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>227,256.4</b>	<b>338,231.6</b>	110,975.20	49%
Татвар	1,502.2	2,801.2	1,299.00	86%

Ариг гал ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 371,8 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн.

Үүнд: НӨАТатварт -4,9 сая төгрөг,

НДШимтгэлд -24,5 сая.төгрөг,

Газрын төлбөрт -115,6 сая төгрөг,

ҮХХТатварт -40,6 сая төгрөг, ХХОАТатварт -15,4 сая төгрөг,

ААНОАТатварт-170,9 сая төгрөг тус тус төлсөн.

**Гурав. 2020 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилтын биелэлтийн талаар**

Ариг гал ХК нь хөрөнгө оруулалттай охин компаниудын болон хувьцаагаар хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагааг дэмжин ажиллах, нөхцлийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэхийн тулд дараах ажлуудыг Кашмер Холдинг ХХК-ний тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ. Ариг гал ХК-нийн бэлтгэл, ширмэл үйлдвэрлэлийн барилгын 4700 метр квадрат талбайн дээврийн засварын ажлыг шинэ технологи нэвтрүүлэн өөрсдийн ажилчдын хүчээр 102,0 сая төгрөгөөр,

- хүүхдийн цэцэрлэгийн байрны агааржуулалтын 45,0 сая төгрөгөөр,
- ТП-3 –ын трансформаторын тос солих,
- засвар үйлчилгээг 9,0 сая төгрөгөөр,
- ажилчдын авто зогсоолын 936м2 талбайг засварлах ажлыг 5,0 сая төгрөгөөр,
- дээврийн прапедин ханын 140метр.кв талбайн өрлөгийг 9,0 сая төгрөгөөр,
- стадионы хашааг шинэчлэн засах ажлыг 3,0 сая төгрөгөөр,
- ажилчдын цайны газрын агааржуулалтыг 18,0 сая төгрөгөөр,
- цэвэр усны станцаас флататор хүртэлх Ф150 дулааны 150метр хос шугам болон дулааны лоток, таг зэргийг шинэчлэх ажлыг 32,0 сая төгрөгөөр, нийт 178,0 сая төгрөгийн ажлыг хариуцан гүйцэтгүүлэн ажлыг хүлээн авлаа.
- Баянзүрх дүүргийн 15-р хорооны 12,13-р байрны 161 айлын орон сууцны 1991 онд ОХУ-ын эрх бүхий байгууллагаас түрээсийн гэрээ байгуулж ажилчдаа оруулж түрээсэлж байсан цагаас хойш 30 жилийн дараа уг сууцанд сууж амьдарч байгаа ажилчиддаа үнэ төлбөргүйгээр хувьчлан авч өглөө.

Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд 30 жилийн хугацаанд 700,0 мянга гаруй ам.долларын зардал гарган олон хууль бус үйлдлүүдийг шүүх, арбитрайн байгууллагаар шийдвэрлүүлж хууль бус үйлдлүүдийг таслан зогсоож, байр болон түүний шугам сүлжээ, их, бага засваруудыг өөрийн компаниар гүйцэтгэж, орон сууц өмчлөгчдийн холбоог байгуулан ажилласныхаа үр дүнг 2020 онд үзэж 161 айл өрх тохилог дулаан орон сууцныхаа эзэн боллоо. Манай компани нь ийм олон ажилчдынхаа нийгмийн асуудлыг зэрэг шийдсэн, мөн олон жил тууштай хөөцөлдсөний үр дүнд орон сууцыг ажилчдынхаа нэр дээр шилжүүлж чадсанд бахархалтай байна.

Үйлдвэрлэлийн компаниудын цахилгаан эрчим хүчийг хэвийн хангахын тулд УБ хотын цахилгаан түгээх станцаас РП хүртэлх 10 кВа-гийн ерөнхий тэжээлийн 2 секцийн 125-ын кабель 40 жил ажиллаж моралийн элэгдэлд орсон. Энэ шугам дээр гэмтэл гарч 2 муфтыг сольсон бөгөөд цаашид шинээр солихын тулд техникийн нөхцлийн зөвшөөрлийг зохих байгууллагаас авч 2021 онд ойролцоогоор 165,0 сая орчим төгрөгөөр солихоор төлөвлөж хэвийн ажиллагааг хангахаар ажиллаж байна.

Хувьцаагаар хөрөнгө оруулалттай Монноос ХК-ийн угаах үйлдвэрлэлийг ажилд оруулахын тулд ТЭЦ-3 –аас технологийн уур авах, дулаан, цахилгаан, цэвэр ус авах эрхүүдийг сэргээж ажиллах нөхцлийг бүрдүүлэх эрх зүйн бичиг баримт, төсөв төлөвлөгөөг хариуцан хийж гүйцэтгэж байна.

Дэлхийн бүх улс оронд гарсан цар тахал улмаас үйлдвэрлэлийн хэмжээ буурч захиалга багассан ч гэсэн ажилчдаа ажлаар тасралтгүй хангаж нийгмийн даатгалын шимтгэлийг тасалдуудахгүй, ажлын байраа хадгалахын төлөө бүхий л хүч чармайлтаа гарган ажилласан.

2020 онд гарсан цар тахал (ковид-19)–аас шалтгаалж 2019 оноос экспортын борлуулалт 4,0 тэрбум төгрөг буюу 28%-иар, дотоод борлуулалт 7,7 тэрбум төгрөг буюу 48 хувиар буурч компаниуд хүнд нөхцөлд орсон ч нийгмийн хариуцлагын хүрээнд хариуцлагаа хүлээн ажилчдынхаа цалинг цаг тухай бүрд нь зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж олгосноор мэргэжлийн ажилчдаа хамгаалан авч үлдэж чадлаа.

Үйлдвэрлэлийн компаниудын үйлдвэрлэлтийн хэмжээг 2019 онтой харьцуулахад:

- Монмяндас ХХК – 70477 ширхэг сүлжмэл буюу 24,1 хувиар
- Эвсэг Од ХХК – 39625 ширхэг нэхмэл буюу 46,9 хувиар,
- Тансаг Ширээс ХХК – 1759 ширхэг буюу 13,0 хувиар тус тус буурсан.
- Кашмер Ходинг ХХК нь 2019 онд 165 тонн түүхий ноолуур авч байсан бол 2020 онд 37,0 тонн түүхий ноолуур авснаас шалтгааж Хавт Шонхор ХХК-ний анхан шатны үйлдвэрлэл 78 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үйлдвэрлэлд зориулан авах түүхий эдийн хэмжээ багассан ч нөөц бололцоогоо ашиглан хоёрдогч түүхий эдийг дахин ашиглаж ноолууран хөнжил, Говийн Мяндал ХХК-ниар 2551 ширхэг бэлэг дурсгалын зүйл, жижиг эдлэл, Тансаг Ширээс ХХК-иар 6384 ширхэг хөнжил, 592 ширхэг зүүмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.

#### **Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар**

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэц нь ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээр ажиллаж байгаа манай хувьцаа эзэмшигчид мэдэх болсон билээ. Энэ жил ч энэ бүтцээрээ ажиллаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер ходдинг ХХК- иуд харъялагдаж байгаа.

Кашмер холдинг ХХК-ийн харъяанд түүний охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд орж байна.

Группийн харъяа компаниудаас хувьцаагаар хөрөнгө оруулалттай Мон ноос ХК, Дорнод ноос ХК-иуд бас группийн харъяалалд хамаарагдан өргөн хүрээнд үйл ажиллагааг явуулж байгаа.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулж эдгээр бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого удирдлагаар хангаж ажилладаг.

ТУЗ-ийн даргын АА нь ТУЗ-д туслах чиг үүрэгтэй бөгөөд группийн харъяа компаниудыг ТУЗ-өөс явуулж байгаа удирдлага, менежментийн бодлогыг хэрэгжүүлэх, харъяа компаниудын ажлыг дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах, урамшууллын бодлого журмыг боловсруулах, мөрүүлэх, ажлын үр компаниудын удирдлагуудыг урамшуулах асуудлыг ТУЗ-ийн даргад оруулж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулахад холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, түүний дагуу компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулах зэрэг ажлыг үр дүнд хүргэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ирлээ.

"Ариг гал" группийн харъяа компаниудын дүнгээр 23.0 тэрбум төгрөгийн орлоготой, 554,4 сая төгрөгийн ашигтай ажиллаж, улсын төсөвт 1,1 тэрбум гаруй төгрөгийн татвар шимтгэлийн орлого төвлөрүүлж ажилласан. Улс оронд болон дэлхий нийтэд цар тахал гарч компаниудын үйл ажиллагаа нэлээд доголдож нийт компаниудын борлуулалтын орлого өмнөх оноос 46.6%-иар цэвэр ашиг өмнөх оноос 6.2%-иар буурсан.

Группийн харъяа үйлдвэрлэлийн компаниуд нь эх орныхоо "сэргээгддэг баялаг" болсон Монгол ямааны ноолуураар олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тэдгээрээс цөөнгүй нэр төрлөөр гадаад, дотоодын нэр хүндтэй байгууллагуудын шагнал, өргөмжлөлийг хүртсээр ирсэн билээ.

Хэдийгээр хөл хорионы нөхцөл байдлын улмаас цөөнгүй удаа үйл ажиллагаагаа зогсоосон боловч 2020 оны жилийн ажлаа дүгнэж, Группийн "шилдэг", "манлайлагч", "тэргүүний" ажилтнаар 11 ажилтныг шалгаруулж 6.5 сая.төг-өөр, Компани бүр "Шилдэг" ажилтнаа шалгаруулж, 5 ажилтныг 3.1 сая.төг-өөр, мөн зэргийн шагналд нийт 38 ажилтныг 13.1 сая.төг-ийн шагналыг олголоо. Мөн жилийн ажлын үр дүнгээр группийн нийт 800-аад ажилтнуудад 125.7 сая.төг-ийн үр дүнгийн урамшууллыг олголоо.

Группийн хэмжээнд ажилтнуудыг ажлын үр дүнгээр нь хөхүүлэн дэмжих зорилгоор мастер, нэгжийн удирдлагад ажилтнаа урамшуулах эрх олгож, түүний дагуу сар бүрийн урамшуулалд, **263** ажилтныг **21.7** сая.төг-өөр, шинэ санаа гаргалт г.м менежментийн ажлын үр дүнгээр давхардсан тоогоор **3041** ажилтны **85.0** сая.төг-өөр урамшууллаа.

Компанийн үнэт зүйлийн нэг болсон мэргэшилтэй ажилтнуудын тогтвор суурьшлыг хангах нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд **3** ажилтанд орон сууц авах урьдчилгаа төлбөрт **73.0** сая.төг-ийн, **9** ажилтныг их дээд сургуульд сургаж сургалтын зардлаар **26.2** сая.төг-ийн санхүүжүүлт хийлээ.

#### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь**

Өнөөдөр тус компанийн хувьцааг өнөөдөр 7360 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Хувьцааны 39.98%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99%-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байна.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээтүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон МХБ, СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн байгаа.

Компани өөрийн хувьцааны 3.2%-ийг халаасласан байна. Бусад 43.2%-ийн хувьцаа нь 7360 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа болно.

#### **Зургаа. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.**

Тус компани 2018 онд нийт ашгийн 25%-иар нэгж хувьцаанд 32.49 төг буюу нийт 113.0 сая.төг-ийг, 2019 онд нийт ашгийн 60%-иар, нэгж хувьцаанд 32.92 төгрөг буюу нийт 135.0 сая.төг-ийг тараасан. 2020 оны ашгын 40%-иар буюу нэгж хувьцаанд 38.93 төгрөг буюу нийт 135.4 сая.төг-ийг 2021 оны 6 сард багтаан зарлаж байна.

### **Долоо. Цаашид хийх ажил**

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэх, цар тахлын үед ажлын байраа хадгалж үлдэх бүхий л нөөц бололцоог бүрдүүлж дэмжлэг үзүүлж ажиллах.
2. Компаний ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд ашиглагдахгүй байр талбайг чөлөөлж, үйлдвэрлэлийн талбайг нэмэгдүүлж ажиллах орчныг сайжруулж түрээсийн орлогоо нэмэгдүүлэх.
3. Олон жил хадгалсан зарим сэлбэг, тоног төхөөрөмжийг борлуулж талбайгаа чөлөөлөх.
4. Ариг гал ХК-ний охин компани болох “Метрополитан проперти” ХХК, “Блюскай таур” ХХК – ниудын үйл ажиллагааг эхлүүлэн бие даан ажиллуулж, ашиг орлоготой болгох.
5. Ариг гал ХК-ний эзэмшил газрын бүрэн бүтэн байдлыг хадгалан хамгаалах, зарим хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах зэрэг арга хэмжээг авах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Гүйцэтгэх захирал Х.Хания



## “АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮГНЭЛТ

### Нэг. Санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдлаар талаар

2020 оны эцэст компанийн нийт хөрөнгө 58.4 тэрбум төгрөгт хүрч, тайлант жилийн хугацаанд 1.9 тэрбум төгрөгөөр буюу 3,1%-иар буурсан байна. Энэ бууралт нь үндсэндээ урт хугацаат хөрөнгө оруулалт 8,9% - иар ын буурсан, хуримтлагдсан алдагдлын хэмжээ 1.6 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд богино хугацаат өр төлбөрийн хэмжээг 379,6 сая төгрөгөөр, урт хугацаат өр төлбөрийн хэмжээг 25,0 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна. Группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэн охин компаниудын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд толгой компани нь аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа учраас өглөг авлагын дийлэнх хувийг охин компанитай хийх тооцооны авлага өглөг эзэлж байна. Гэхдээ авлагын үлдэгдэл 36,8 тэрбум төгрөг байхад богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 49,5 тэрбум төгрөг байгаа нь даруй 12,7 тэрбум төгрөгийн зөрүүтэй байгаагийн шалтгааныг гүйцэтгэх удирдлагын зүгээс тайланд тодорхой тусган дүн шинжилгээ хийж харуулаагүй хэвээр байна. Хожим тодруулснаар зонхилох хэсэг нь ханшийн зөрүүгийн алдагдлаар хаагдах ёстой байна. Энэ их хэмжээний алдагдлыг хэсэгчлэн хааж байх талаар тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Тайлангийн хугацаанд урт хугацаат зээлийн үлдэгдлийг 25,0 сая төгрөгөөр бууруулж чадсан байна.

### Хоёр. Орлого, зардал, ашиг

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг охин компаниудад шилжүүлж, үйл ажиллагааг нь зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг хангах зэргээр холдингийн толгой компанийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа учраас нь орлогын эх үүсвэр нь:

А. Ногдол ашиг	1,514,331.5 сая төгрөг
Б. Түрээсийн орлого	236,144.1 сая төгрөг

В. Бусад орлого гэсэн хэлбэртэй байна.

Түрээсийн орлого төлөвлөснөөс 170,0 орчим сая төгрөгөөр буюу 41 хувиар буурсан нь дэлхий дахиныг хамарсан цар тахалтай холбогдуулан удаа дараа хөл хорио тогтоосноос группын компаниудын үйлдвэрлэл, борлуулалт, үүний дотор дотоод боруулалт болон экспортын хэмжээ аль аль нь ихээхэн буурснаас орлого буурч түрээсийн гэрээг цуцалсантай холбоотой. Өөрөөр хэлбэл компанийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар орлого буурсан байна. Хөрөнгө оруулсан компаниас авсан ногдол ашгийн хэмжээ төлөвлөснөөс 364,0 орчим сая төгрөгөөр өссөн нь орлогын төлөвлөгөө бага зэрэг давж биелэхэд нөлөөлсөн байна.

### Зардал

2020 онд зардлын хэмжээ төлөвлөсөнөөс 87,6 сая төгрөгөөр буюу 12 хувиар өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал өссөнөөс шалтгаалсан байна.

### 4. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв

Цар тахал нь хөл хорио тогтоох, хил хаах зэрэг арга хэмжээг урт хугацаагаар авснаас шалтгаалан группын хэмжээнд тайлант онд санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны түвшингээс буурсан байна. Группын компаниудын борлуулалтын орлого өмнөх оноос 46,6 хувиар, цэвэр ашиг 6.2 хувиар буурсан боловч энэ нь компанийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаантай байна.

### Дүгнэлт

Өнгөрсөн жилийн тайлангаар өгсөн үүрэг даалгаварууд үндсэндээ хэрэгжсэн байна.

Мөн түүнчлэн энэ жилийн **үйл ажиллагааны тайлан** нь өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад агуулгын хувьд дэлгэрэнгүй болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Өнгөрсөн онд цар тахлын улмаас хөл хорио тогтоож, хил хаасан зэргээс компанийн үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагаа ихээхэн хумигдсан боловч ниймгийн хариуцлагын хүрээнд ажилтнуудынхаа **ажлын байрыг хадгалж, цалин олгосоор** ирсэн нь томоохон амжилт гэж дүгнэж байна.

**Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх** тал дээр багагүй амжилт гаргасан байна. 30 орчим жил үргэлжилсэн байрны маргаантай асуудлыг эцэслэснээр 160 гаруй өрхийн орон байрны асуудал шийдвэрлэгджээ.

3 ажилтанд орон сууцны урьдчилгаа олгосон байна.

**Урамшууллын үр дүнтэй тогтолцоо нэвтрүүлсэн** нь зохих үр дүнд хүргэжээ.

**Дотоод аудитын тогтолцооны** үр дүн дээшилж, нэгэнт хэвшсэн тогтолцоо болж, компанийг үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэлээс хамгаалах чиглэлд амжилт гаргаж чадсан гэж дүгнэж байна.

2014 оноос хэвшүүлж ирсэн дотоод аудитын тогтолцоо нь ТУЗ -ийн Ажлын албаны бүтцэд хамаардаг бөгөөд Ерөнхий аудиторын удирдлагын дор Санхүүгийн болон үйл ажиллагааны аудит гэсэн үндсэн хоёр чиглэлээр аудитын үйл ажиллагааг сар бүр тогтмол хэрэгжүүлж, үр дүнг ТУЗ-д мэдээлэн мөрөөр нь холбогдох арга хэмжээ авч, үр дүнд хүрэх хүртэл байнгын хяналт тавин ажиллаж хэвшжээ. Аудитын явцад илэрсэн зөрчил доголдол, түүнийг засахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал зэргийг үр дүнгийн урамшуулал олгохдоо үндэслэл болгож хэвшсэн байна.

Группын охин компаниудын **үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт их засварын** ажлыг нилээд өргөн хүрээтэй хэрэгжүүлж чадсан байна. Тухайлбал, хуявцаагаар хөрөнгө оруулалттай Монноос ХК-ийн угаах үйлдвэрийг ашиглалтад оруулах чиглэлээр хийсэн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн компаниудын цахилгаан эрчим хүчний кабель шугамын засвар шинэчлэлийн ажлын эхлэл зэргийг дурьдаж болно.

Эдгээрт үндэслэн компанийн менежментийн багийн үйл ажиллагаа хэвийн сайн явагдаж, үүргээ зохих ёсоор биелүүлж чадсан гэсэн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

## **АУДИТЫН ХОРОО**

"Ариг гал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар

хувьцаа эзэмшигчдээс **САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог:.....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн регистрын дугаар:.....

Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо:.....

Хурал хуралдах хугацаа: 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр. 17.00 цагт

Хурал хуралдах хаяг: ХУД.19-р хороо. Зайсангийн гудамж . Үйлдвэрийн парк 18-01 тоот байр. Хурлын танхимд


дд	хуралд оруулж буй асуудал	хурлаас гарах шийдвэр	зөвшөөрсөн (+)	татгалз сан (-)	санал	
1	Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсож хэлэлцэх	тайланг батлах				
2	Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэх	дүгнэлтийг батлах				
3	Төлөөлөн Удирдах Зөвлөлийг сонгох					
<b>А</b>	<b>Энгийн гишүүд</b>	ТУЗ-ийн энгийн гишүүдийг сонгож батлах				
1	С.Мөнхжаргал					
2	Д.Гиваапил					
3	Д.Мөнхбат					
4	Сэ.Алимаа					
5	Х.Хания					
6	Б.Ёндонжамц					
<b>Б</b>	<b>Хараат бус гишүүд</b>		ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгож батлах			
1	Б.Болд					
2	Б.Аюуш					
3	Э.Бямбажав					
4	2020 оны НА-ыг нэгж хувьцаанд 38.93₮ буюу нийт 135.4 сая.төг (нэг зуун гучин таван сая дөрвөн зуун дөчин тавуан мянган)-өөр тооцож олгох тухай хэлэлцэх	2021 оны 6 сард багтааж зарлаж олгох				
5	2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэх	зардлын төсвийг 42810.0 мян.₮ -өөр батлах				
6	Охин компанид биет хөрөнгөөр ХО-ыг нэмэгдүүлэх ТУЗ-ийн 2020 оны 08.20 болон хөрөнгийн эх үүсвэр гаргах тухай 10.20 тоот шийдвэрүүдийг танилцуулах	ТУЗ-ийн шийдвэрийг дэмжиж батлах				

Саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацаа: 2020 оны 04 сарын 23 -ний өдрийн 12.00 цаг

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....(.....)  
( гарын үсэг ) (овог нэр)

Саналын хуудсыг хүчинтэй (хүчингүй)-д тооцож тоолсон, тооллогын комиссын дарга:.....( Ч.Энхцэцэг )  
(доогуур нь зурах)

Гишүүд: .....(Б.Мөнхтуул )  
.....(Д.Мөнхбаатар)



**“АРИГ ГАЛ” ХК**  
**ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ХУРЛЫН**  
**ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30- ны өдөр

Дугаар 01.21

Улаанбаатар хот

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Ч.Энхцэцэг, тооллогын комиссын гишүүн Д.Мөнхбаатар, Б.Мөнхтуул нар байлцан биеэр хуралд оролцсон .....ш, цахимаар ирүүлсэн .....ш буюу нийт..... санал бүхий .....ш саналын хуудас тоологдлоо. Саналын хуудаснаас хүчингүй .....санал (байхгүй), хүчинтэй ..... санал бүхий .....ш хуудас тоологдсоноос хуралд оруулсан асуудал бүрт дараах санал өгөгдсөн байна. Үүнд:

1. Хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн..... буюу .....%-ийн саналаар Гүйцэтгэх захирлын Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг, ..... санал буюу .....%-ийн саналаар ТУЗ-өөс компанийн Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах санал өгөгдсөн байна.

2. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив ..... санал буюу .....%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, ..... буюу .....%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, ..... санал буюу .....%-ийн саналаар Д.Мөнхбатыг, ..... санал буюу .....%-ийн саналаар С.Алимааг, ..... санал буюу .....%-ийн саналаар Д.Гиваапилийг, ..... санал буюу .....%-ийн саналаар Х.Ханияг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,

Кумулятив ..... санал буюу .....%-ийн саналаар Б.Аюушийг, ..... санал буюу .....%-ийн саналаар Э.Бямбажавыг, ..... санал буюу .....%-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгох санал өгсөн байна.

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... саналаар буюу .....%-ийн саналаар 2020 оны цэвэр ашгийн 40.0%-иар буюу нэгж хувьцаанд 38.93₮ буюу нийт 135.4 сая.төг (нэг зуун гучин таван сая дөрвөн зуун дөчин таван мянган)-өөр хуваарилахаар гаргасан ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 10-ны өдрийн 12/20 тоот тогтоолыг дэмжсэн санал өгсөн болно.

4. Хувьцаа эзэмшигчдийн ..... буюу .....%-ийн саналаар Компанийн удирдлагын 2021 оны зардлын төсөвийг зардлын төсвийг 42810.0 мян.₮ (дөчин хоёр сая найман зуун арван мянган)-өөр батлах санал өгчээ.

5. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... буюу .....%-ийн саналаар Тус компаниас “Кашмер холдинг” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг 31.0 сая.төгрөг (гучин нэгэн сая)-ийн үнэ бүхий биет хөрөнгөөр нэмэгдүүлж, уг үл хөдлөх хөрөнгийг дагалдуулан эзэмшил газрын эрхийг “Кашмер холдинг” ХХК-д шилүүлсэн тухай ТУЗ-ийн 2020 оны 11 сарын 04-ны өдрийн 8/20 тоот тогтоол,

Мөн “Корона вируст халдвар” ихээр тархаж, гадаад улсад явуулах ачаа тээвэрлэлтийг хязгаарласнаас харъяа компаниудын экспорт бүрэн зогссон, хөл хорионоос дотоод борлуулалт эрс буурснаас шалтгаалан, компанийн зарим хөрөнгийг эргэлтэд оруулж, санхүүгийн эх үүсвэр олж, өр төлбөр барагдуулах зорилгоор компанийн барилгын зүүн хэсэгт байрлах “Үйлдвэрлэл”-ийн зориулалттай газраас 12.0 мян.ам.м (арван хоёр мянган ам.м) хүртэл хэсгийн эзэмших эрхийг худалдах замаар өр төлөх зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгосон ТУЗ-ийн 2020 оны 06 сарын 15-ны өдрийн 10/20 тоот тогтоолуудыг тус тус дэмжсэн санал өгөгдсөн байна.

6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын дүнд тооллогын комиссын гаргасан дүгнэлтийг, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулахаар шийдвэрлэв.

Тооллогын комиссын тэмдэглэл хөтөлсөн, Тооллогын комиссын гишүүн:


(Д.Мөнхбаатар)

Тэмдэглэлтэй танилцаж зөвшөөрсөн,  
тооллогын комиссын дарга :

(Ч.Энхцэцэг)

Тооллогын комиссын гишүүн :

(Б.Мөнхтуул)



**“АРИГ ГАЛ” ХК  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30-ны өдөр

Дугаар 01.21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын  
тооллогын дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4, 63.5 дугаар заалт, 72 дугаар зүйлийг удирдлага болгон “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал хураах хуудсаар өгсөн нууц санал хураалтад явуулсан тооллогын дүнгийн тухай тооллогын комиссын Т-01.21 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн..... буюу .....%-ийн саналаар Гүйцэтгэх захирлын Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг, ..... санал буюу .....%-ийн саналаар ТУЗ-өөс компанийн Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах батлах,

2. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив ..... санал буюу .....%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, ..... буюу .....%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, ..... санал буюу .....%-ийн саналаар Д.Мөнхбатыг, ..... санал буюу .....%-ийн саналаар С.Алимааг, ..... санал буюу .....%-ийн саналаар Д.Гиваапилийг, ..... санал буюу .....%-ийн саналаар Х.Ханияг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,

Кумулятив ..... санал буюу .....%-ийн саналаар Б.Аюушийг, ..... санал буюу .....%-ийн саналаар Э.Бямбажавыг, ..... санал буюу .....%-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгох,

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... саналаар буюу .....%-ийн саналаар 2020 оны цэвэр ашгийн 40.0%-иар буюу нэгж хувьцаанд 38.93₮ буюу нийт 135.4 сая.төг (нэг зуун гучин таван сая дөрвөн зуун дөчин таван мянган)-өөр хуваарилахаар гаргасан ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 10-ны өдрийн 12/20 тоот тогтоолыг дэмжсэн,

4. Хувьцаа эзэмшигчдийн ..... буюу .....%-ийн саналаар Компанийн удирдлагын 2021 оны зардлын төсөвийг зардлын төсвийг 42810.0 мян.₮ (дөчин хоёр сая найман зуун арван мянган)-өөр батлах,

5. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... буюу .....%-ийн саналаар Тус компаниас “Кашмер холдинг” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг 31.0 сая.төгрөг (гучин нэгэн сая)-ийн үнэ бүхий биет хөрөнгөөр нэмэгдүүлж, уг үл хөдлөх хөрөнгийг дагалдуулан эзэмшил газрын эрхийг “Кашмер холдинг” ХХК-д шилүүлсэн тухай ТУЗ-ийн 2020 оны 11 сарын 04-ны өдрийн 8/20 тоот тогтоол, Мөн “Короно вируст халдвар” ихээр тархаж, гадаад улсад явуулах ачаа тээвэрлэлтийг хязгаарласнаас харъяа компаниудын экспорт бүрэн зогссон, хөл хорионоос дотоод борлуулалт эрс буурснаас шалтгаалан, компанийн зарим хөрөнгийг эргэлтэд оруулж, санхүүгийн эх үүсвэр олж, өр төлбөр барагдуулах зорилгоор компанийн барилгын зүүн хэсэгт байрлах “Үйлдвэрлэл”-ийн зориулалттай газраас 12.0 мян.ам.м (арван хоёр мянган ам.м) хүртэл хэсгийн эзэмших эрхийг худалдах замаар өр төлөх зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгосон ТУЗ-ийн 10/20 тоот тогтоолуудыг дэмжиж, батлахаар санал өгсөн тооллогын дүнг ХЭХ-д оруулж батлуулсугай.

6. Хуралд оролцогчдын саналын хуудсаар өгсөн саналд явуулсан тооллогын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Тооллогын комиссын дарга (Ч.Энхцэцэг)-д даалгасугай.


Тооллогын комиссын дарга :

(Ч.Энхцэцэг)

Тооллогын комиссын гишүүд :

(Д.Мөнхбаатар)

(Б.Мөнхтуул)



**“АРИГ ГАЛ” ХК  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30- ны өдөр

Дугаар 01.21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын  
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9-дэх хэсэг, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.21 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... буюу .....%-ийн саналаар Компанийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, ..... буюу .....%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг батласугай.


2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, компанийн өртөг зардлыг бууруулах, ашгийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөгөөр тавьсан зорилтыг биелүүлэх бодитой арга хэмжээг хэрэгжүүлэн, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Д.Гиваапил

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг



**“АРИГ ГАЛ” ХК  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30- ны өдөр

Дугаар 02.21

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож,  
батлах тухай.

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/21 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив

- ..... санал буюу ..... %-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Д.Мөнхбатыг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар С.Алимааг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Б.Ёндонжамцыг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Д.Гиваапилийг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Х.Ханияг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,
- Кумулятав ..... санал буюу ..... %-ийн саналаар Б.Аюушийг,
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Э.Бямбажавыг
- ..... санал буюу ..... %-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгосныг баталсугай.


2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (С.Мөнхжаргал)- д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Д.Гиваапил

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг



**“АРИГ ГАЛ “ ХК**  
**ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30- ны өдөр

Дугаар 03.21

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах  
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 12.20 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.21 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ..... санал буюу ..... %-ийн саналаар 2020 оны цэвэр ашгийн 40.0%-иар буюу нэгж хувьцаанд 38.93₮ -өөр (гучин найман төгрөг 93 мөнгө) тогтоосугай.

2. Ногдол ашигт зарцуулагдах 135.4 сая.төгрөг (нэг зуун гучин таван сая дөрвөн зуун дөчин таван мянган) -ийг компанийн ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.

3. Компанийн мөнгөн гүйлгээний боломжтой үед зохицуулан, 2021 оны 6 дугаар сард багтаан Ногдол ашгийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай


Хурлын дарга

Д.Гиваапил

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг





**“АРИГ ГАЛ” ХК  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дүгээр сарын  
30-ны өдөр

Дугаар 04.21

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг  
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 хэсэг, хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.21 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын 2021 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн .....санал буюу ердийн олонхийн ..... %-ийн саналаар 42810.0 мян.₮ (дөчин хоёр сая найман зуун арван мянган)- өөр хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжрагал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Д.Гиваапил

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг

